



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 01 сарын 28 өдөр

Дугаар А/30

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "а", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.1.5, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Коронавирус (covid-19) цар тахлын өвчлөлийн тархалт омикроны дэгдэлт аймгийн хэмжээнд нэмэгдэж байгаатай холбогдуулан түргэвчилсэн оношлуур, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэх, эмнэлгийн ор дэлгэх тооцоог хавсралтаар баталсугай.

2.Дээрх зардалд шаардагдах 129,402,400 (нэг зуун хорин есөн сая дөрвөн зуун хоёр мянга дөрвөн зуу) төгрөгийг Гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Ц.Идэрсайхан)-д зөвшөөрсүгэй.

3.Түргэвчилсэн оношлуур, хамгаалах хэрэгслийн нөөц бүрдүүлэх, эмнэлгийн ор худалдан авах талаар аж ахуйн нэгжүүдээс үнийн санал авч худалдан авалт хийхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Эрүүл мэндийн газрын дарга (Д.Шивааннүрдэв)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0067

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2022 оны
...дүгээр сарын ...-ны өдрийн
...дугаар захирамжийн
хавсралт



Түргэвчилсэн оношлуур, хамгаалах хэрэгслийг
бүрдүүлэх, ор дэлгэх тооцоо

№	Түргэвчилсэн оношлуур, хамгаалах хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодисын нөөц бүрдүүлэх нэр төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт үнэ
1	Түргэвчилсэн оношлуур	2800	12500	35,000,000.0
2	Комбинзон	2040	16800	34,272,000.0
3	Түрүүтэй углааш	488	3200	1,561,600.0
4	Үзлэгийн бээлий / хос /	20000	640	12,800,000.0
5	Нэг удаагийн халад	2000	4800	9,600,000.0
6	Цогцос хадгалах уут	20	25000	500,000.0
7	Шүүлтүүртэй амны хаалт N95	2000	2500	5,000,000.0
8	Гутлын улавч	1296	300	388,800.0
9	Нүүрний хаалт	2000	2480	4,960,000.0
10	Эмнэлгийн ор	27	730000	19,710,000.0
11	Хөнжил, гудас	51	110000	5,610,000.0
Нийт дүн				129,402,400.0